



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

“Дарь эх ундарга хоёр” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг батлах тухай 245 дугаар тогтоолын хавсралтын 7.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарь эх ундарга хоёр” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Цаашид тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд ирүүлэх, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Дарь эх ундарга хоёр” ХЗХ /С.Сарангоо/-нд анхааруулсугай.
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтад холбогдох тэмдэглэгээг 21 хоногийн дотор хийлгэхийг “Дарь эх ундарга хоёр” ХЗХ /С.Сарангоо/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН